



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 362

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Гаалийн ерөнхий газрын харьяа газар хороодын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5 нэрийн нийт 5,498,122,717.00 (таван тэрбум дөрвөн зуун ерэн найман сая нэг зуун хорин хоёр мянга долоон зуун арван долоон) төгрөгийн балансын үнэ, 144,672,950.92 (нэг зуун дөчин дөрвөн сая зургаан зуун далан хоёр мянга есөн зуун тавин төгрөг ерэн хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу "Мэдээлэл холбооны сүлжээ" хязгаарлагдмал хариуцлагатай компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Гаалийн ерөнхий газрын дарга Р.Отгонжаргал, "Мэдээлэл холбооны сүлжээ" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гүйцэтгэх захирал Б.Мөнхбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулж, данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ГАНБОЛД

132005231

18-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн
362 дугаар тогтоолын хавсралт

Гаалийн ерөнхий газрын харьяа газар, хороодын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй "Мэдээлэл
холбооны сүлжээ" хязгаарлагдмал харууцлагатай компанид шилжүүлэх шилэн кабелийн
жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалта д орсон огноо	Хэмжээ	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ (төгрөг)	Нийт хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Эзэмшигч байгууллага
1	Шилэн кабелийн сүлжээнд холбох /Эрэнцэв/	10/5/2022	км	5.8	18,115,922.07	105,072,348.00	3,502,411.60	101,569,936.40	Дорнод аймаг дахь гаалийн газар
2	Шилэн кабелийн сүлжээнд холбох /Баянхошуу/	10/5/2022	км	304.9	8,193,554.92	2,498,214,896.00	83,273,829.90	2,414,941,066.10	Дорнод аймаг дахь гаалийн газар
3	Шилэн кабелийн сүлжээнд холбох /Арц суурь/	10/5/2022	км	44.4	8,951,659.41	397,453,678.00	7,949,073.54	389,504,604.46	Завхан аймгийн Арцсуурь боомт
4	Шилэн кабелийн сүлжээнд холбох /Ханги/	10/5/2022	км	263	7,079,323.08	1,860,446,106.00	37,208,922.12	1,823,237,183.88	Сайншанд дахь гаалийн газар
5	Шилэн кабелийн сүлжээнд холбох /Бургастай/	10/5/2022	км	75	8,515,183.01	636,935,689.00	12,738,713.76	624,196,975.24	Завхан аймгийн Арцсуурь дахь гаалийн хороо
	Нийт дүн	-	-	692.7		5,498,122,717.00 (таван тэрбум дөрвөн зуун ерэн найман сая нэг зуун хорин хоёр мянга долоон зуун арван долоон)	144,672,950.92 (нэг зуун дөчин дөрвөн сая зургаан зуун далан хоёр мянга есөн зуун тавин төгрөг ерэн хоёр мөнгө)	5,353,449,766.08	-